



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 25 өдөр

Дугаар А/41

Зуунмод

Зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.13, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, вакцинжуулах, хариу арга хэмжээ авах, Батсүмбэр суманд дэмжлэг үзүүлэх, автомашинд шаардлагатай сэлбэг, хэрэгсэл худалдан авахад шаардагдах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

2.Үйл ажиллагаанд шаардагдах 12,088,000 (арван хоёр сая наян найман мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт)-т зөвшөөрсүгэй.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (М.Отгонбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

Аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр
сарын 25 -ны өдрийн А/41 дүгээр
захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ТООЦОО

№	Байгууллагын нэр	Хэмжээ /төг/	Зориулалт
1	Хуурай замын цэргийн командлал	2,088,000	Албан хаагчдын томилолт
2	Онцгой байдлын газар	1,000,000	Сэлбэг
3	Мал эмнэлгийн газар	1,000,000	Шатахууны дэмжлэг
4	Батсүмбэр сум	5,000,000	Санхүүгийн дэмжлэг үзүүлэх
		1,500,000	"Универсал" тракторын сэлбэг хэрэгсэл
5	Урал автомашин	1,500,000	Өвс, тэжээл тээвэрлэх шатахуун
Нийт		12,088,000	-

___оОо___